

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойровын Дондов	Дугаар	L126
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Мөнххаан
Төрсөн газар	Мөнххаан	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Боонгийн хийд, Мөнхааны хүрээ, Номун хааны хийд, Өндөр Майдарын хийд, Цагаанчулуутын хийд	Сүм хийдийн дугаар	СБМХ 058, СБМХ 053, СБМХ 052, СБМХ 062, СБМХ 051
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймаг Мөнххаан сумын Боонгийн хийд, Мөнхааны хүрээ, Номун хааны хийд, Өндөр Майдарын хийд,
Цагаанчулуутын хийд

-Бид 1937, 38 оноос өмнө Монгол оронд байсан хуучны сүм хийдийн тухай, тухайн үед хийдэд шавилан сууж байсан болон энэ тухай мэдэх хүмүүстэй үулзаж мэдээ баримт цуглуулж явна. Та Мөнххаан сүмд байсан сүм хийдүүд болон бусад ойролцоох сумын хийдүүдийн тухай мэдэх зүйлээ хэлж өгнө үү?

Баруун гуут, Зүүн гуут чинь баруун зүүн Хайлантын энгэрт байгаа энэ хийдийн харъяа хийдүүд шүү дээ. Гол хийд нь Далай вангийн Дашчойнхорлин хүрээ шүү дээ. Хүрээ гэдэг чинь том 1000 гаруй ламтай , Шүтээний аймаг, Чойрын аймаг, Майдарын аймаг, Хур сангийн аймаг гэсэн 4 аймагтай 4 худагтай байлаа. Очоод үзэхэд одоо 3 худаг нь баларсан. Шүтээний аймгийн худаг гэдэг нь л байна . Хур сангийн аймаг гэдэг чинь аймгийн зүүн талын аймгийн нэр. Би нялхаасаа эхлээд 9 нас хүртэл хийдийг нуртал нь л байсан манай эцэг хийдийн Гэсэр шүтээний тахилч хийж байсан . Манай энэ сүм Гэсэр шүтдэг ганцхан сүм. Гэхдээ хятадын Даогийн шашны гэсэр биш жинхэнэ монгол Гэсэр. Гэсэр хааныг монгол нутагт

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шүтэж байсан ганцхан газар нь Мөнххаан. Түүний тахилчийг миний эцэг 1937 онд хаагдтал нь хийж байсан.Өөрөө Дүйнхорт 25 жил хурсан. Гэсэрийн тахилчийг 25 жил хийсэн хүн. Мөн энэ хошууны хамгийн алдартай бишгүүрч байсан.

-Далай вангийн хошуу хийд хэдэн дацантай байсан бэ?

Далай вангийн хошуу хийд Гол хүрээ нь Дашчойнхорлин хүрээ. Далай вангийн хошууны харъяа одоо Баян-Овоо сумын Жавхлант уулын энгэрт Жавхлант хийд гэж байсан. Одоогийн Батноров, Норовлин сумын нутагт байсан хийд бол тэр үедээ Далай вангийн нутагт харьяалагдаж байсан . Энэ хошуу бол ходоодон хэлбэртэй хошуу байсан. Урд талын Уулбаян сум, Баруун урд талд хуучин Өлзийтын наад талд, баруун Бүрэнцогт, зүүн талд Баянтэрэм сум эд чинь бүгд манай хошуу . Ловон ламыгаа нас барахаар энд суваргалж оршуулчихаад хойшоо нүүгээд Хоолой худгийн шүтээн гэж тэнд байж байгаад 1937 онд хаагдсан одоо суурь чулуу нь бий.

Хуучин Ловонгийн хийд нь Мөнххаан уулын Их тахилгын энгэр дээр байсан одоо ором нь бий. Зоогийн шандны хойно байгаа. Зоогийн шанд гэдэг маань Ловон ламын хийдийн лам нарын ундаа байсан учраас зоог гэж нэрлээд байгаа учир нь тэр. Хэрлэн голтой тэнцэх хамгийн сайхан тэнцүү хадан ёроолоос гарсан сайн худаг байсан одоо ч гэсэн зуны халуунд уухад шүд тас хийнэ. Тэрнээс зүүн тийш болохоор Энгэр булаг, Эрдэнэ уул гэж бий. Машин замын зүүнтэй Хавхчин худгийн Хавхчин хийд гэж байсан . Тэгээд зүүн тийшээ явахаар Лаансын ганжуур, Баруун гуут, Зүүн гуут урагшаа эргээд Баянтэрэм сумын төв дээр өндөр Майдар. Өндөр. Майдарын хийд гэж бусдаасаа том Дүйнхортэй, нямбатай. Тэгээд зүүнтээ Хоолой худгийн шүтээн гэж байгаа. Боонгийн хоолой гэж Эрдэнэдалай вангийн хошууны бүх баялаг буян энэ хоолойгоор гадагшаа гарч байна гэж үзээд Баянцагааны зүүнтэй Боонгийн шүтээн гэдгийг байгуулаад баялагаа гадагш нь гаргахгүй боож байх зорилготой хурал хийж байсан. Боонгийн шүтээн гэдэг чинь түүндээ байгаа юм боож байх зорилготой.

Мөн Татаад цагаан гэж хийд байсан. Татна гэсэн үг.Тэгэхээр манайд Боонгийн хийд гэж байсан эндээс харахад хоёр хошууны хооронд тэмцэл байгаа биз дээ. Аймгийн урд Ар тойрмын говийн дэргэдүүр явахаар намхан хийд байгаа Их цагаан гэдгийн тэрнээс баруун тишээ Бага цагаан гэж байдгийн их цагааны энгэр дээр Татаад цагаан гэж Татаадын жаахан хийд байсан юм гэнэ лээ. Энэ Уулбаян сумын өөрийнх нь төвийн баруун хойно Дөрвөлжингийн хийд гэж байсан манай хошууны урд гэсэн үг. Тэгээд баруун эргэхээр Баруун ганжуурын хийд гэж баруун урд байсан. Ганжуурын хийд Манжийн эзэн хаанаас мэдээтэй чийгатай, шунхан Ганжуур залсан юм гэнэлээ. Анх үүссэн шалтгаан нь манай баруун хошууны нэг тайж гүн хэргэмтэй болох гэж хээл хахуул цутгасан юм гэнэ лээ. Гэтэл Манжийн хаанаас мэдүүтээ хэн гүнгийн зэрэг горьдож хээл хахууль цатгасан гээд шалгаад ирэнгүүт тайж "Бид баруун Ганжуурынхаа хийдийн шунхан Ганжуурыг гүн хэргэмтэй болгох гэсэн юм гэж мултарсан юм гэнэ лээ. Ийм учиртай. Тэгээд манай Гэсэр шүтээн Манжийн эзэн хаанаас талархсан чийгатай байсан. Чийга гэдэг чинь баталгаа бичиг гэсэн үг шүү дээ. Гэсэр шүтээн үүдэндээ том дөрвөлжин хайстай тэнд утасны мод шиг өндөр мод гозойгоод орой дэр нь догтой. Дог мод хоёрынхоо завсар сүм хэлбэртэй дөрвөлжин савтай тэрэн дотроо чийга нь хадгалаатай шилэн нүүртэй байдаг байсан. Жаахан дөрвөлжин дотор чинь чоги нь байж байдаг зөвшөөрлийн бичиг гэсэн үг л дээ. Одоо чийганы учрыг мэддэг юм уу үгүй юм уу чийгатай хүрээ хийд байдаг юмуу мэдэхгүй.

-Чийганы хоёр мод байдаг байсан уу?

Нэг л мод байдаг байсан.

Манайх чинь монгол Гэсэр. Гэсэрийг улаан зээрд морьтой гэж бий шүү дээ түүхэнд. Гэсэрийг тахих үед улаан зээрд морийг дөрвөлжин хайснаас чөдөрлөөд үүдэнд нь уядаг байсан. Шал эмнэг улаан зээрд морь байдаг байсан. Гэсэр шүтээний сан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болох адуунд л байдаг байсан байх. Сүүлдээ 1936-37 онд байхгүй болсон. Би аавыгаа дагаад үргэлж тэрүүгээр гүйж явдаг байсан болохоор сайн мэдэж байна. Гэсэр шүтээн дэлгэмэл бурхан хадаг самбай нь дарагдсан нандин бурхан байсан. Цонхоор хүн өнгийх гэвэл цаашаа бай гэж хорьдог байсан.Тийм ёслолгоотой байсан . Хонины зумаар дайлдаг. Хонийг алаад битүү бөгсөөр нь бүх гэдэс гүзээг нь аваад гал дээр хуйхлаад тэрийгээ хойшоо хараад хэвтэж байгаагаар бурхандаа тавьдаг. Сүүлд нь сайхан болсон гадартай мах шууэлаад л хувааж өгдөг байсан. Шар халзан хониор тахидаг. Манай Гэсэр бол жинхэнэ монгол Гэсэр. Гэсэр бурханы эмээл гээд эмээл нь ч байсан. Гэсэр баатрыг л бурханчлан шүтэж байсан газар. Гэсэрийн сан тахилгатай. Гал тогоо нь болох зэс тогоо модон тагтай, тулга нь 4 хөл нь галд үрссэн байсан. Тэгээд дээр нь баатрын хувцас ,хөө, хуяг, дулга, нум, сум бүгдийг нь 4 хөлтэй битүү ширээнд углаад яг хүн байж байгаа юм шиг байлгаж Гэсэрээ хурдаг. Энэ Мөнххаан уулыг тахихад тэр Гэсэрийг дэргэд нь аваачиж тавьдаг ийм учиртай байсан юм.

Дээр үед Пү. Хорлоо багш судалж ирсэн юм. Монгол Гэсэр гэж монголд Гэсэр шүтдэг газар байхгүй юм дандаа. Хятадын Даогийн гэсэр байсан юм гэхэд манай Очирчүлтэм дарга битгий худлаа хэл. Манай Мөнххаан сумын Далай вангийн хошууны Гэсэр гэдэг чинь жинхэнэ монгол гэсэр байсан юм. Бид Гэсэрийн наадам хийхэд үрээг нь унаж байсан юм гэж. Ингээд сайн мэдэх хүн байна үү гэхэд эцэг нь Гэсэр шүтээний тахилчийн хүү Дондов гэдэг багш байгаа гэж. Би хотод байсан намайг зориуд дуудаж уулзаж байсан юм. Тэгээд Пү. Хорлоо Гэсэрийн тухай бичээд нэг сэтгүүлд хэвлэсэн гэж байсан. Шинжлэх ухааны тэр үеийн сэтгүүлд л хэвлэсэн байх. Одоог хүртэл олж үзээгүй. Би 3-9 нас хүртлээ тэр тахилганд байнга явсан болохоор мэдэж байсан. Хуучин тахилгаа бодвол нэлээд хөнгөрчихсөн байсан. Дээр үед ноёд байх үед бол чийганы 2 талд 2 эрээн асар зоодог байсан. Баруун талд лам нар нь суугаад зүүнд нь хошуу ноён түшмэлүүд нь суудаг хар шар хоёр асар байдаг байсан. 1930-аад оны үеэс хойш байхгүй болсон. Манайхны Махширын ээж Цэнд гэж хөгшин байна. Үрээг нь унаж байсан. Мөнххаан уул чинь буугаад тахихлаар баруунтаа нарийн луу гэдэг дээр тахидаг тэнд ноён эрээн асар хатгасан өөрөө очсон байдаг байлаа. Соёолон азарга гэсэн хоёр нас уралдуулдаг ёстой байсан.

Номун хааны хийд гэдэг чинь бол Ламын лхан гэдэг юм. Лхан гэдэг чинь төвдөөр хийд гэсэн үг. Ламын гэдэг нь Номун хаан ламаа хэлээд байгаа юм. Хамгийн сүүлийнх нь Нанзаддорж гэж байгаад баригдсан. Гаравын номун хаан ,Цагаан номун хаан гэж гурав дөрөв хувилчихсан. Номун хааны хүрээ байгаа юм. Цагаан номун хааных нь шарил энэ ламын лхан дээр суварган дотор ил байсан. Шаваад, дэвээд алтдаад тавьсан, Гаравын номун хааных нь энэ зүүн Өндөр майдар хийд дээр байсан юм байна лээ. Ангалгүй Наваан гуай ярьсан юм. Сүүлд нь дөрвөлжин бунхтай булшинд газар булсан байсан. Цагаан номун хааных бол хийдийг нураахад л цуг нурсан. Суварган дотор нүүр нь суварганы дээд талын бумбаар нь шилэн нүүртэй цан нь алтадсан бурхан шиг л шар юм байсан даа. Тэр л Цагаан номун хааных л байсан юм байна лээ. Монхордуу хамартай. Ажаа л монхор цагаан лам байсан юм даа. Өөртэй нь их адилхан байсан юм ш дээ гэж байсан. Шарилыг нь, өөрийг нь шавж байгаа юм болохоор адил бололгүй яхав дээ .

-Гаравын номун хаан ,Цагаан номун хаан хоёр чинь өөр хүмүүс юм үү.

Өөр өөр Цагаан номун хаан гэдэг чинь анхных нь. Тэгээд Гаравын номун хаан гэдэг нь энэ зүүнтэй байсан. Хамгийн сүүлийн Номун хаан гэж тодорсон 20 хэдтэй залуу хулсан ташуур барьсан хүүхэн дагуулаад давхисан. Майдар, сор дээгүүр давхиж явдаг. Намжиддорж гэдэг хүн байж байгаад баригдсан.10 жил болоод суллагдаад Налайхад байж байгаад үхсэн байх.

-Нанзаддорж гэдэг хүн Цагаан Номун хааны хэд дэхь дүр нь вэ?

Би мэдэхгүй хамгийн сүүлийнх гэхээр 4,5 дахь нь л байх.Энэ хоёрын бунхалсан шарил байсан юм гэнэлээ. Бусдыг нь нутаглуулаад байсан юм шиг байлээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнххааны хүрээ гэдэг чинь л энэ Ловон ламын шүтээн гэдэг чинь ш дээ Бага тахилганы энгэр дээр байсан. Далай вангийн хүрээ Рашаантын нуур гэж урд талынх нь нуурыг хэлээд байгаа юм уу даа .Рашаантын нуурын хойно байсан одоо суурь нь тэнд байгаа. Наад талын бидэнд харагдаж байгаа баруун талын овоотой чинь баруун Цацагт овоо гэдэг юм. Хийдийн хойд талаар хойд Цацагт овоо гэж бий. Хоёр цацагт овоотой байсан. Лам нар гардаг уншлагатай байсан. Баруун Хойд хоёр дүгийн овоо чинь бас лам нар гарч ном уншдаг байсан. Хорин дээрээ дом тавьсан лам нар ганган эмээл хазаартай сайхан морио унаад хамаг гоё хувцасаа өмсөөд шар дүгтэй тэгээд энэ 2 баруун зүүн дүгийн овоон дэр ирж ном уншдаг. Овоо нь гэрэн хэлбэртэй зүүнтэй нь нураад юу ч үгүй болж баруунтайх нь жаахан гэр хэлбэр нь байгаа юм. Дүгийн овоо гэдэг чинь Түгийн овоо болсон юм. 30 хэдэн он болтол дом тавьсан. 20 насны лам нар 20 настай домоо тавиад заавал Дүгтэй энэ 2 дээр гарч ном уншиж тахидаг байсан шүү.

Цагаан номун хааны хийд гэж хэлээд байгаа нь анхных нь дүрээр хэлээд байгаа юм. Сүүлдээ бол Ламын лхан ламын лхал гэх болсон

Баруун ганжуурын хийд тэр. Хавхагтын хийд гэдэг чинь тэр. Цээл нуур гэж ярихгүй. ердөө Хавагтынх нь худгийн тэнд байсан юм байлээ. Бумбатын хойно бараг ором байхгүй. Яваад очвол яахав дээ, энд байсан юм байна гэж мэдэгдэхээр чулуу бий. Тэнд чинь Улаан сахиус шүтдэг. Ер манай хошуу Жамсран улаан сахиус шүтдэг хошуу тийм учраас энд нандин сахиус гэр хэлбэртэй модон дуганд Жамсран улаан сахиус ганцаараа. Тийм айхтар үнэтэй цайтай эдлэлээр бүтсэн хадганд боодолтой жи гэсэн үсэгтэй л юм байсан.Тэр нь тэр хэвээрээ Ганданд байж байгаад сүүлдээ би сураглаад алга гээд байсан. Тэгсэн одоо Гандан хийдийн цаана хадгалсан нандин шүтээнд байгаа юм байна лээ. Уг нь энэ хийддээ авчирч залая гэж хөөцөлдөж байсан юм. Эрдэнэ гүнгийн хийд гэж байсан. Эрдэнэ уул гэдэг газар ганцхан жижиг хийд байсан. Баянтэрэм сумын нутагт байгаа Өндөр майдрын хийд. Мөн сумын нутагт байгаа Зүүн ганжуурын хийд. Баянтэрэмийн харъяа чинь манай Мөнххааны хийд. Тэгэхээр Хоолой худгийн хийд гэдэг чинь Даржаалин шүтээн гэж. Хоолой худгийн шүтээн тэр нь нөгөө боох зорилготой чинь энэ байхгүй юу. Хоолойн худаг гэхээсээ Боонгийн Баянцагаан гэдэг.

Хоолой худгийн хийд ч Даржаалин ч гэдэг юм. Мөн сумын Цагаанчулуутын хийд. мөн сумын Боонгийн хийд гэж бий Их саваа уул гэж нутгийнхнаас сураглавал мэднэ. Уулбаян сумын харъяанд байгаа Дөрвөлжингийн хийд. Энэ манай хошууны урд захын хийд. Даян сумын Өндөр майдарын хийд, Зүүн ганжуурын хийд, мөн сумын хамжлагын хийд, тэгээд баруун зүүн гүүд Хамжлагын хийдийг Гэлэргавжаалин хийд гэдэг байсан байгаа.

Хамжлагын хийд Цогт уулынхаа шилийн холбоо гэдэг газар баруун зүүн Гүүтаас зүүн тийш байсан. Манай хошуу 20-иод хийдтэй байсан бүгдээрээ Дашчойнхорлин хийдийн харъяа хийдүүд. Наран сарангийн уул гэж байсан Наран саран 2 уулынхаа нарангийн энгэр дээр байсан юм уу тэгээд л Наран булгийн хийд гэж нэрлэсэн байх л даа. Энэ маань хилийн холбоогоосоо зүүн урагшаа өөрөөр хэлбэл Баянтэрэм сумаас зүүн хойшоо. Манай хувилгаан ах энэ тэрийн ид нутаглаж байсан газар чинь Наран,Сарангийн уул юм шүү дээ .

Хувилгаан ах чинь ямар хүн байсан бэ?

Төмөр бургасын хувилгаан буюу Лувсан-Ёндон хувилгаан гэж байсан. Би төрсөн дүүгийнх нь хүүхэд байгаа юм .

-Цагаан чулуутын хийд гэдэг маань аль хийдийг хэлж байна? Бид Их булагаас зүүн урагш Юүншээв худгаас зүүн урагш Цагаан овоо гэж байна лээ. Яг цагаан Овооны энгэр дээр байгаа хийд мөн үү? Урдаа Өлзийт гээд овоотой Баянцагаан дөрвөлжин гэж уултай?

Тэр чинь мөн байх. Бас дөрвөлжингийн хийд гэж ярьдаг тал бий шүү. Гэхдээ энэ Баянтэрэмийн наана бас Дөрвөлжингийн хийд гэж байдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Түвшинширээ суманд бас Цагаанчулуутын хийд гэж байх ёстой. Цагаантолгой ч гэдэг Бүдүүн ухаа ч гэдгийн Цагаан ухаа ч гэдэг. Улсууд янз бүрээр нэрлээд байдаг юм. Одоо ч айл нутаглаж байдаг. Тэрнээс жаахан урагшаа яваад Баяндэлгэрээс хойш Түвшинширээгээс урагшаа Ламтны хийд гэж бий Лагт гэдэг газар байрлаж байгаа. Тэр чинь бас Түвшинширээ ,Баяндэлгэрийн харъяа хийдийн нэг шүү. Орлой гурван зээрд онгон таван булгаас баруун урагш. Баруун, Зүүн, Дунд гурван Орлой гэдэг чинь Баяндэлгэр сумын арын гурван зэрэгцсэн уул шүү дээ. Тэрнээс жаахан баруун тийшээ. Баяндэлгэрийнхэн жинхэнэ баруун сүрэгчин хошуу шүү дээ. Хуучин Дарьгангын Баруун гар тэмээчин баруун гар хоньчин гэж хүрээ ордог их замаасаа баруунтааг нь Баруун зүүнтээхийг нь Зүүн гэж байсан дээр үед. Тэгээд энэ Түвшинширээ хуучин дандаа Дарьганга гарлууд Сүрэгчин хошууных.

-Тэгэхээр тэрний дээд талынх нь болохоор Зүүн ганжуурын хийд гэж байж. Зүүн ганжуур маань юу гэдэг газар байрлаж байв?

Мэдэхгүй би Зүүн ганжуурт очиж үзээгүй Хоолойн худгийн тэнд байгаа шүтээнээ Зүүн ганжуур гэж байгаа юм уу. Ямар ч гэсэн Далай вангийн хошуу Баруун, Зүүн хоёр Ганжууртай л байж. Одоогийн Уулбаян , Баянтэрмэн Мөнххаан чинь цөмөөрөө нэг хошуу юм байна.Зүүн хойшоо явахаар энэ Баян-овоо сумын нутагт байгаа хийдүүд чинь манай Далай вангийн харьяа хийдүүд шүү дээ. Аймгийн зүүн хойд талынх нь Мөст ухаа хошуу. Мөсөн сумын нутагт байгаа. Норовлинд Улзын голын урд Мөстийн хийд нь манай хошууны хамгийн арын хийд

-Тэгэхээр Зүүн ганжуурын хийд нь Хоолойн худгийн хийд болж байна уу? Хоолойн худаг Мөнххаан сумаас зүүн хойшоо чигтэй байна уу?

Тийм. Баянтэрэмээс зүүн хойшоо, Баянтэрэм уулаасаа бол хойшоо Хоолойн худаг бий. Зүүн зүрхийн хоолой гэж ярьдаг юм шүү. Наран Сарангийн уулаас нэлээд цаашаа. Тэгээд урагшаагаа явахаар гайхамшиг гэдэг ийм л юм шүү дээ. Намайг нэг настай байхад хувилгаан ахынхтай айл бууна гэж Наран Сарангийн ууланд очиж бууж байсан.

-Өндөр Майдарын хийд бол яг шинэ булаг гэдэг газар?

Тийм. Анхны хувьсгалч Догсомын төрсөн газар. Өндөр Майдарын хийд бол хуучин Баянтэрэм сумын төв дээр шүү дээ.

-Дээшлээд Энгэр уулын хийд гэдэг маань Эрдэнэ уулын хийд болж таарч байна уу?

Энгэр булаг гэж баруун хойд дэвийн зүүн талаарх хошуурсныг нь ханан гэдгийн хойд талыг нь хэлдэг. Энгэр булгийн худаг гэдэг нь урагшаа Цагаан нуурынхаа хойд дээр байгаа.

-Хавхагтын хийд маань Цээл нуур гэхгүй яг Хавхагтын худгийнхаа дэргэд байгаа юу?

Хавхагтын худгийн дэргэд . Хавхагтын худаг гээд баруун тийшээ эргэсэн хадан мөргөцөгтэй худаг байгаа. Тэгвэл тэрүүний зүүн талын ухаагийн урд энгэр дээр Хавхагтын хийд гэж байсан. Тэр үед айхтар хундаам ухаагүй чулуу газар дээр өрөөд барьчихаж байсан юм болохоор балгасачихаж байгаа ийм л байна даа. Дээр үед дотоод яам бүртгэж байсан. Хамгийн гүйцэд бүрэн бүртгэл тэнд байсан. Хожим үстгах гэж. Жинхэнэ иж бүрэн гүйцэд бүртгэл дотоод яамны тэндээс гарсан байна лээ. Лам нараа хийдүүдээ тоол, толгой лам нарыхаа нэрийг өг гэж үүрэг өгөөд тэрний даалгавраар тэгээд тийм хүн хаана байна гэж сураад барьж байсан байгаа юм. 1936 онд Дэмид жанжин чинь манай энд ирсэн юм. Зүүн Рашаантын хойд дэнж дэр нисэх онгоц ирж буугаад бид нисэх онгоц үзээгүй сонирхож Дэмид жанжин чинь тэр орой кино үзүүлж. Даавуун дээр гардаг киног үзээгүй бүгд л сонирхож хөгшин залуугүй очиж үзэж байлаа.Тэгэхэд манай Хамба лам ямаан Дамба гүай эд нартай чинь Дэмид цуг зогсчихсон кино тайлбарлаад байж байсан. Тэгэхэд анх баривчлахдаа За Гэндэн Дэмидийн эсэргүү ямаан Дамба гэж тэр мэтээр л бүгдийг хэлмэгдүүлж байсан. Ёнзон хамбын даалгаврыг дагадаггүй хийдийн хамба гэж байхгүй гээд Лувсан Хайдав Ёнзон хамба гэдэг төвдийг хэлмэгдүүлээд тэрүүгээр бүх лам нарыг хядаад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дууслаа шүү дээ. 1927оны 9 сарын 10-нд Чойбалсангийн анхны тушаал гарсан. Ердөө тэр тушаал гарсан өдрөөс л барьж эхэлсэн. Чойбалсан өөрийн нүгэл хийснийг мэдээд урьд нэг муу лам шуу юм Дорнодын Сансрайдоржийн хийдээс Гэндэн Яринпил хоёулаа оргоод Хүрээнд ирж хонины мах бариад гүйж байсан намтар нь бий шүү. Лам байж байгаад Сталины даалгавраар жаал сүйтгэж давхичихаад наслаагүй 57 л насалсан л даа. Чойбалсан Сталины 60 насны ойгоор ихээхэн бэлэг сэлтэй очсон. 70 насны ойгоор очоогүй. Харьяалж байсан бүх социализм маягтай газруудаас 70 насны ойд хоёрхон удирдагч очоогүй. Нэг нь Чойбалсан Нэг нь Чехословакийн Тито.

Лаансын хийд Баян-Овооны энгэр дээр. Ер нь дандаа л нэг Ганжууртай хийдүүд байсан байна шүү.

-Талын толгойн хийд гэдэг нь хаана байдаг, ямар хийд вэ?

Түмэнцогтын үү?

Түмэнцогтын Талын толгой?

Түмэнцогтын Талын толгой гэдгийг би мэдэхгүй байна даа.

-Баянтэрэм сумаас хойшоо Түмэнцогтоос урагшаа тэрийг болов үү гэж бодож байна.

Баруун ганжуурын хийд дээр манай Ажаа багаасаа сууж байсан. Тэгээд намайг лам болгоход бас өөрийхөө лам болсон Баруун ганжуурын хийд дээр лам болгож байсан. Би Майдар эргэдэг майдарын тэргэн дээр суугаад хийдэд очиж лам болж байсан. Маргааш өглөө нь сэрсэн чинь Ажаа байхгүй би уйлаад нүцгэн ажаагийнхаа хойноос очсон чинь нөгөө лам нар чинь өчигдөр орхимж дэлгэж байсан лам чинь гээд шоолж байсан. Хийд тарж бутраад 1937 оны 10 хэд хоногийн гал бол хамаг хэрэгтэй юмаа галаар устгасан. Тэгээд л байхгүй болсон.

-Хийдүүд хэдэн онд байгуулагдсан, хэр олон дугантай, ямар нэртэй байсан талаар яриач?

Би энэ хийдээ мэдэхээс бусад хийдийг бол мэдэхгүй шүү дээ.Банзрагчийн шинээр бичсэн хийдийн тухай ном байна уу. Тэрэн дээр бол хийдүүдийн байгуулагдсан он сар ер нь дэлгэрэнгүй байгаа байх.

Мөнххааны хошуу хийд хэдэн онд байгуулагдсан гэдэг вэ?

1666 онд л манай энэ Дашчойнхорлин хийдийн анхны үндэс тавигдсан байгаа. Ганданд хадгалаатай байгаа энэ эрдэнээр бүтсэн хадгаар цуглаатай Жамсран улаан сахиусыг чинь л анх энд залж байлаа. Нэг домог байдаг Жамсран улаан сахиусыг анх шүтэх гээд дуганыг нь барих гээд хаана барих вэ гэж ярилцжээ. Газар шинждэг нэг хятадаар шинжүүлсэн. Тэр хятад энд зүгээрээ гээд нэг зоос булсан байгаа. Сүүлд нь Номун хаанаар үзүүлсэн. Аль Номун хаан нь юм мэдэхгүй тэр үзээд энд зүгээрээ гээд сумаар хатгасан, тэгсэн сумных нь үзүүр хятадын булсан зоосны нүхээр орсон байсан гэдэг. Тэр суурин дээр Ганжуур шүтээн гэж гэр дуган байсан. Одоо сорив нь бий. Цанидын дуганы их дөрвөлжин суурины зүүхэн хойно бий. Тэр гэр хэлбэртэй модон дуганд л Жамсран улаан сахиус ганцаараа ердөө хурал ном хурдаггүй. Орж л тахил махил түй аравнайг нь өргөдөг болохоос өөр юмгүй тийм байсан. Бид бол нэрийг нь хэлэхгүй. Нандин сахиус гээд л дуганыг тойроод л мөргөөд явна. Човонбо л орно Сүүлд 1937 оны үед чинь Човомбо нь ч хүртэл зугатаагаад манай эцэгт түлхүүрээ өгөөд 10-д хоног хөдөө яваад ирье гээд намайг иртэл түй аравнайг нь өргөж байгаарай гээд нэг мэдэхнээ хийдийн бүх түлхүүр манай эцэгт байж байсан. Нэг өдөр сумын захиргааны Шийлэгдугар гэж сумын захиргааны нарын бичгийн дарга хийж байсан урьд нь ламшуу юм хийж байсан хүн тэр дуудаж байна. За та энэ хийдийн бүх түй аравнайг өргөөд яваад байна. Түлхүүрээ нааш нь өгөх үү үгүй юу гэсэн гэж байгаа. Тэгсэн би яаж мэддэг юм. Хөдөө гараад л тахилч нар нь ирэхгүй болчихсон. Тэгээд уурандаа түлхүүрийг нь гаргаж ширээн дээр нь тавьчихаад л гарсан юм гэнэ лээ. Тэгсэн Гэсэр шүтээнд байсан өөрийхөө нэг нь 50 лангийн нэг нь 25 лангийн хоёр мөнгөн бишгүүрээ авалгүй түлхүүрээ өгчихсөн гэдэг юм. Би мөн муншуу хүн шүү. За би түлхүүрээ гэрээсээ аваад ирье гээд гараад Гэсэр шүтээнээсээ хувийнхаа хоёр мөнгөн бишгүүрээ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аваад түлхүүрээ өгчихөж болох байсан. Өргөлөөсөө худалдаж авсан хувийнх нь юм байсан юм л даа. Мундаг гоё дуутай цагаан мөнгөөр хийсэн бишгүүр байсан юм. Би бол хоёр мөнгөн бишгүүрийг нь сайн мэднэ. Одоо Ганданд хоёр мөнгөн бишгүүр байдаг. Манай эцгийнхээс жижиг юм байна лээ. Тэгээд манай эцгийн мөнгөн бишгүүр бол эмээлийн хэрэглэл болсон л доо.

Гэндэнсэнгэ гэж хүн хийдийн шүтээнийг хадгалж байсан. Гэндэнсэнгэ чинь Сандуй гэлэн гуайн шавь гээд хийдийн хойдох Зүүн овооны хойд энгэр дээр байсан. Залуугийн ийм хөлгүй таягтай байсан. Тэгээд нэг шөнө чи Ганжуур шүтээний цонхоор ороод Нандин улаан сахиус тийм тийм юмыг аваад ир гэж. Хийд тарчихсан хүнгүй байсан цонхоор нь ороод дүүжлээтэй байсныг аваад ирсэн. Тэрийг хадгалсаар байгаад Сандуй гэлэн гуайг нас барахлаар Чимэдданзан гээд өвгөнд хадгалуулсан байсан тэр нь би болохгүй боллоо чи анхнаасаа авч байсан хүн хадгал гэсэн.Тэгээд Гэндэнсэнгэ гуай насан эцэс болтлоо л зул өргөж, ном уншиж байсан. Тэгээд л Улаанбаатарт Ганданд аваачиж өгсөн юм гэсэн. Тэгэхэд Гандангийн хамба манай Баян-овооны хийдийн лам байсан С.Гомбожав өө манай хошууны Нандин сахиус авалгүй яахав гээд. Тэгээд л Ганданд хадгалагдсан юм даа. Гомбожав гуайн эцэг бол манай энэ Дашчойнхорлин хийдэд хүрж байсан гэдэг. Би бол Жавхлантын хийдэд л байсан хүн гэж ярьсан байна лээ.

-Номун хааны, Мөнххааны хошуу хийдийн талаар? хэдэн ламтай хэдэн дугантай байв?

Ламын лханы хийд чинь харин байнгын нэлээн лам нартай байсан. Лам нарын гэр нь зүүн талаараа байсан. Очоод би энэ лам нарын гэрийн бууриуд гээд хэлчихэж чадна.Нэг Цогчэнтэй байсан. Цогчэн дуганыг нь сүүлд буулгаж ирээд манай энд хоршооны склад хийж байгаад нурлаа. Манба дацан байсан Ламын лханд. Намайг 1936 оны үед очиж үзэхэд Цагаан ламын суварга байсан.

-Суурин дээр нь суварга босгосон байна лээ. Тэр ямар учиртай юм бол?

Тэр суваргыг жинхэнэ Цагаан Номун хааны шарилын суурь дээр босгоогүй. Зүүн доогуур нь Манба энэ тэр гээд цувсан хийдүүд байсан тэр дээр босгосон байна лээ. Тэгэхэд хамгийн хойно нь дуган дотор Цагаан номун хааны жаахан суварга байсан. Модон дуган дотор суварга байсан.

-Тэгвэл суварга босгосон газар нь юу болох вэ?

Цогчэн дуган байсны хойно л босгож дээ. Би очиж үзсэн суваргаа их муухай хийсэн байна лээ.

-Номун хааны хийд хэдэн дугантай байсан?

Цөөхөн цөөхөн. Хамгийн том дуган нь Цогчэн дуган байж байгаад сүүлд ноосны байшин байж байгаад нурлаа.

-Энэ хошуу хийд хэдэн дугантай байсан бэ?

Дөрвөн аймаг байсан.

-Дөрвөн аймгийн хэдэн дацан байсан?

Зүүн хойд Майдарын аймагт Майдарын хийд байсан. Чойрын аймгийн дуганы хажууд бас нэг бурхан хадгалдаг орж гардаг жижиг дуган байсан. 20 настай залуу лам нар дом тавихдаа заавал тэр Чойр дуганд очиж дом тавьдаг байсан. Голын Цанидын дуганд ордоггүй. Голын Цанидын дуган гэдэг нь сүүлд шатсан хойно нь Хэцүү далай бэйсийн үед барьсан Цанидын дуган гэдэг юм. Тэгээд оронд нь дан модоор модон дуган барьсан. Тэр нь хуучнаасаа жаахан дуган гэж байсан. Гэсэн ч тэр нь талдаа 11 алд байсан. Голдоо дөрвөн том баганатай тэрнийхээ араар бас дөрвөн нарийвтар баганатай байсан. Хуучин шатдаг хийдийн зураг нь манай энд хадгалаатай байсан чинь үрэгдээд алга болж. Хамгийн баруун урдах нь Шүтээний аймаг, тэгээд Чойрын, Майдарын аймаг, тэгээд Хурал сан гэж аймаг байсан

-Хурал сан ямар учиртай аймаг вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хурлын сан хөмрөг хадгалдаг байсан. Зарим нь Сангаа аймаг ч гэж хэлж байсан. Майдарын аймаг бол дотроо олон гудамтай тогтмол суудаг лам нар нь 800 гаруй, тэгээд зуны улирал өвлийн их хурлаар 1000 гаран болчихдог. Шүтээний аймгийн худаг нь хойноо байсан. Энд хөндлөн байшин байсан. Тэр нь одоогоор хоолны агуулах гал тогооны газар байсан. Цанидын дуганы зүүн хойно энд нөгөө сахиусны гэр хэлбэртэй дуган байсан. Зүүнтэй нь арай бага дөрвөлжин .Энэ нь Дүйнхорын Цанидын дацангийн баруун талд байгаа нь Жүдийнх. Жүдийн дуганы модыг тэр чигээр нь буулгаад анх мал эмнэлэг барьсан. Сүүлд нь нэгдэл склад болгосон. Нэгдэл тарахлаар нь би хувьцаандаа аваад гэрийнхээ гадаа хураасан байгаа. Энэ Жүдийн дуган хааш хаашаа 11 алд байсан Хуучин дуган нь 20 алд, түүхий туйпуугаар барьсан дотроо 16 баганатай байсан. Нэг баганых нь бүдүүн хоёр гараа алдлаад тойруулахад дутаж байсан гэж ярьдаг тийм бүдүүн модоор хийсэн байж. Эргэн тойрон төвд маягийн хээтэй дугуй шар тольтой, төвд маягийн дөрвөлжин хүрээтэй. Тэгээд дээр нь ахиад хонхтой ийм 3 юм байсан. Намайг 25-тай байхад шатсан юм гэж манай эцэг ярьж байсан. Цанидын дуганы арханд Манба хойшоогоо Ламримын хийд гээд энд байсан. Тэгээд л Майдар гээд майдарын аймаг дотор дугантай, Чойр гээд чойрын аймаг дотор дугантай, Шүтээний аймгийн өөрийн аймгийнх нь дуган гэж бас томоо дөрвөлжин дуган байсан юм. Хурал сангийн аймаг харин дуган багатай. Шүтээнийх нь дуган гээд жижиг дуган байсан. Нийтдээ 14 дацан л байсан юм. 14 дацан гэдэг чинь 14 дуган байна мэдээж хэрэг. Лам нар суугаад хурдаг газраа бурхан гэхээр юм байхгүй тийм зохион байгуулалттай л байсан юм даа. Шүтээн нь хийдийн горооны гадаа мөргөлчдийн гороолоод тойрдог дотор байсан. Хийдүүд нь нэг аймагт эгнэхлээр 4-5 эгнээ л байсан. Нэг эгнээндээ 10-аад айл байдаг байсан. Бас харчуулын хороо гэж байсан

-Хошууны төв хаана байсан бэ?

Тамгын газар нь энэ Банзар толгойн энгэрт байдаг байсан. Тэнд ноён нь л байна. Хатнуудынх нь гэр зүүн хонхорт. Баруун овооны хөтөл дээгүүр Жасаа толгой гэж байсан. Тэнд тамгын жасаа байсан. Тамгын таван түшмэл гэдэг чинь тэнд байсан. Тамгын жасааны шүүдэг банзаддаг шаахайддаг газар чинь банзар толгойн ард. Шорон нь бол Жасаа толгойн зүүн хойд талд байлаа. Банзар толгойн энгэрт байгаа ноёны өмнүүр морьтой гарвал торгодог. Заавал бууж морио хөтөлж өнгөрдөг байсан

Энд ном барладаг байв уу? Бархан байсан уу?

Тийм юм байгаагүй. Ганц нэг хүнд бар бол байсан байх.